



## Сургууль руу орох, гарах дүрэм

И Эс Эм олон улсын дунд сургууль дахин нээгдэж, сурагчдын танхимын сургалт буюу давтлага сургалт явагдах үед эрүүл ахуйн хэм хэмжээг зохих өндөр түвшинд байлгаж, сурагч, багш, ажилчид, зочдын аюулгүй байдал, эрүүл мэндийг аливаа эрсдэлээс сэргийлэн хамгаалахад тус дүрмийн зорилго оршино.

1. Сургууль руу нэвтрэх орцуудыг сургуулийн гадна, урд талын талбайд байрлуулсан байна. Орцууд нь тусгаарлалтын туузаар тэмдэглэгдэж зохих тэмдэг, санамжтай байна.
2. Сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчид сургууль руу зохих дүрмийг баримтлан тодорхой хуваарийн дагуу нэвтрэхийг зөвшөөрнө.
3. Эцэг эх, асран хамгаалагч нь сурагчийн халууны өндөр хэмтэй эсэх, ханиаж найтаасан байдалтай эсэх, хоолой ам нь сөөнгө, хөндүүр эсэх, бие сулбагар, царай цонхигор, тууралттай эсэх гэх мэт халдварт өвчний шинж тэмдгүүдийг үргэлж анхааран тандаж байна. Эдгээр болон ЭМЯ-ны зөвлөмжийн дагуу бусад шинж тэмдэг илэрч байвал Эцэг эх, асран хамгаалагч нь сургуульд явуулалгүй нэн даруй сурагчид зохих эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх шаардлагатай.
4. Сурагчид дүрэмт хувцас өмсөхгүй.
5. **Эцэг эх, асран хамгаалагч нь сургалтын төлбөрийн хугацаа хэтэрсэн аливаа үлдэгдэлгүй байна.**
6. Сургууль руу нэвтрэхдээ газарт байгаа тэмдэглэлийн дагуу тусгаарлалтын 1,5 метрийн зайг бие биенээсээ чанд баримтална.
7. Жижүүр багш сурагчийн биеийн халууныг хэмжиж, амны хаалт зүүсэн эсэхийг шалгаж, гарыг нь ариутган сургууль руу нэвтрүүлнэ.
8. Сурагчид анги руугаа багшгүйгээр орохыг хориглоно.
9. Сурагчид өөрсдийн хувийн хэрэглээний үзэг, бал, харандаа, бусад хэрэглэл, цаас, дэвтэр, сурах бичигтэй байна.
10. Сурагчид ангид зай баримталж зохих тэмдэглэлийн дагуу сууна.
11. Сурагчид нэг ангидаа гарахгүйгээр хичээллэх бөгөөд ариун цэврийн өрөө орохоос өөр сургууль дотор сэлгүүцэхийг хориглоно.
12. Хичээл тарахад сүүлийн хичээл орсон багш сурагчдын гарыг ариутган, амны хаалтыг нь зүүлгэж, зохих зайг бариулан сурагчдаа сургуулийн орц хүртэл гаргаж өгнө. Хичээлийн дараа аливаа сурагч сургуулийн байранд байхыг хориглоно.
13. Сургуулийн хоолны газар ажиллахгүй, өдрийн хоол ундаар үйлчлэхгүй тул сурагчид гэрээсээ зөвхөн зөвшөөрөгдсөн уух зүйлс, хөнгөн зууш/чихэр, жигнэмэг, аливаа хурц үнэртэй хоол биш/-ийг авчирч болно.
14. Сурагчид бэлэн мөнгө авчрахыг хориглоно.
15. Эцэг эх / асран хамгаалагчид орох/гарах цэгээс цааш сургууль руу нэвтрэхийг хориглоно.
16. Эцэг эх, асран хамгаалагчид чухал шаардлагатай, эсвэл яаралтай тохиолдолд сургуульруу нэвтрэхээр бол зохих тэмдэглэл дээр овог нэр, утасны дугаараа тэмдэглэж үлдээж биеийн хэмээ үзүүлсний дараа зочны тэмдэг зүүн хүлээн авах ажилтан, хамгаалагчын заавраар нэвтэрнэ.
17. 2020-2021 оны сурагчдын бүртгэлийг ажлын өдрүүдэд сургуулийн зоогийн танхимд 2020 оны 8-р сарын 31-г дуустал ажлын өдрүүдэд 08:00-16:30 цагийн хооронд хийнэ. Сургалтын алба бүрэлдэхүүнээрээ бүртгэл дээр ажиллах тул эцэг эхчүүд сонирхсон асуудлаа сургалтын албанд мэдэгдэж шийдүүлэх боломжтой.
18. Сургуулийн барилга руу нэвтэрч буй хүн бүр амны хаалт зүүсэн байх бөгөөд орох болон гарахдаа гараа заавал ариутгана.
19. Жижүүр багш болон томилогдсон бүх ажилчид тус дүрмийн биелэлтэд хяналт тавьж ажиллах ба дүрмээ биелүүлээгүй аливаа багш ажилтан, сурагч, эцэг эх, асран хамгаалагчийг сургуулийн байранд нэвтрүүлэхийг хориглоно.



## Designated Guideline and Routes for Entry and Exit

This Guideline is designed to assist in for the safer reopening of ESM. We recognise the importance of returning students to school campuses for in-person instructions, as well as the overarching need to protect the health and safety of our students, school staff, and broader community. Following are the Guidelines and rules to enter and exit through these doors.

1. ESM has designated an area outside, near the main entrance, as a screening station. Each entrance will have signs to guide parents, students, and guardians to use the correct entrance.
2. Junior School, Middle School, and Senior School Students who have followed the guidelines and came to School according to their schedule are allowed to get through the entrance.
3. Parents/guardians are expected to check and monitor for any symptoms of flu or Covid-19.
4. Uniform is not required.
- 5. Students should not have any outstanding tuition fees.**
6. When entering and exiting through the front entrance, everyone must keep a social distance of at least 1.5 meters.
7. Teachers in the designated areas are required to check temperatures, ensure Students have sanitised their hands and are wearing their mask properly.
8. Students are not allowed to enter the classroom without the Teacher/supervisor.
9. Students must bring their own pen, pencil, paper, notebook, and all necessary stationary required for class.
10. Students must sit according to their assigned seats.
11. Students will remain in the same class during the warm-up sessions weeks, they are not permitted to congregate in the restroom or the hallway.
14. Students may not bring cash to School.
15. Parents/guardians are not allowed in the building except in the designated area located in the Dining Hall.
16. In necessary circumstances that Parents, Guardians or Individuals enter the school building they are required to sign in upon entry and sign out upon exit from the school.
17. Registration for the Academic Year 2020-2021 is held in the Dining Hall from 08:00 to 16:30 Monday to Friday until August 31st, 2020.
18. Everyone must wear masks at all times inside the School and must sanitise their hands when entering or exiting the building as well regularly through the day.
19. Teachers must supervise everyone and enforce all the above mentioned guidelines. If anyone (Parents, students, staff, etc.) do not follow the guidelines outlined above they will not be permitted entry in the school.